



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Халхгол сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДОА-2026/082/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Дорнод аймаг</p> <p>2026 он</p>	<p>Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 7058-4203 Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Д.Нармандах Утас: 7058-4207 Цахим хаяг: narmandakh@audit.gov.mn</p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Хаан консалтинг аудит ХХК Гүйцэтгэх захирал: Э.Нандинчимэг Утас: 88883776 Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Баянтүмэнгийн гудамж, 9 дүгээр баг
Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
Утас: 7058-4203

2026.02.25 № 204
танай 2026.01.21 -ны № 5 -т

ДОРНОД АЙМГИЙН ХАЛХГОЛ СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Д.УРАНТОГОС ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорнод аймгийн Халхгол сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

Аудитын гол асуудал

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллаагүй байна.

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

2126050031

Бусад асуудлын хэсэг

Дорнод аймгийн Халхгол сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2025 онд 5 зорилт, 34 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөний биелэлтийг "Хангалттай" буюу 80.4 хувиар үнэлүүлсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	368,627,271.68	243,647,528.29
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	238,801,703.48	99,936,882.79
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	238,801,703.48	99,936,882.79
31211	Төрийн сангийн харилцах	238,801,703.48	99,936,882.79
35	БАРАА МАТЕРИАЛ	129,825,568.20	143,710,645.50
351	Түүхий эд материал	30,850,838.10	34,689,028.40
35110	Тусгай зориулалттай материал	30,290,838.10	34,129,028.40
35130	Эм боох материал	560,000.00	560,000.00
354	Хангамжийн материал	98,974,730.10	109,021,617.10
35410	Бичиг хэргийн материал	371,700.00	177,200.00
35420	Аж ахуйн материал	88,100,702.03	97,300,313.03
35470	Бусад хангамжийн материал	10,502,328.07	11,544,104.07
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	8,003,807,954.26	7,854,872,424.24
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	8,003,807,954.26	7,854,872,424.24
39100	Газар		
392	Биет хөрөнгө	8,003,807,954.26	7,854,872,424.24
39201	Барилга, байгууламж, орон сууц	8,477,702,484.00	8,477,702,484.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(847,770,248.40)	(1,017,324,298.08)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	392,326,069.30	480,193,890.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(135,430,746.93)	(188,227,022.78)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	198,929,183.89	196,162,423.89
39208	Хуримтлагдсан элэгдэл	(104,164,188.60)	(111,850,453.83)
39214	Бусад үндсэн хөрөнгө	20,000,000.00	20,000,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл		(3,999,999.96)
39217	Ном	2,215,401.00	2,215,401.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	8,372,435,225.94	8,098,519,952.53
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	21,362,100.00	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	21,362,100.00	-
413	Өглөг	21,160,500.00	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	201,600.00	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	-
4136	Бусад өглөг	21,160,500.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	21,160,500.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	8,351,073,130.94	8,098,519,952.53
51	Засгийн газрын хувь оролцоо	8,351,073,130.94	8,098,519,952.53
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	521,977,818.50	521,977,813.50
51101	Өмч: - төрийн	521,977,818.50	521,977,813.50
512	Хуримтлагдсан үр дүн	6,402,898,979.93	6,150,345,806.52
51210	Өмнөх үеийн үр дүн	6,442,943,869.51	6,402,898,979.93
51220	Тайлант үеийн үр дүн	(40,044,889.58)	(252,553,173.41)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,426,196,332.51	1,426,196,332.51
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	8,372,435,225.94	8,098,519,952.53

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,210,358,422.60	2,351,355,893.30
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	197,732,922.60	136,875,393.30
120	Нийтлэг татварын бус орлого	197,732,922.60	136,875,393.30
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10,212,348.00	19,977,534.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,928,000.00	2,811,400.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,284,348.00	17,166,134.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	181,682,184.60	101,142,682.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	5,838,348.00	15,755,177.30
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,012,625,500.00	2,214,480,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,671,046,700.00	1,723,120,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,671,046,700.00	1,723,120,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	341,578,800.00	491,360,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	341,578,800.00	491,360,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,093,968,330.18	2,603,909,066.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,093,968,330.18	2,603,909,066.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,044,702,168.67	2,526,524,367.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,224,363,397.53	1,480,884,843.20
210101	Үндсэн цалин	783,533,953.28	911,993,319.64
210102	Нэмэгдэл	393,067,285.68	478,357,254.35
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	49,732,809.21
210104	Урамшуулал	47,762,158.57	40,801,460.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	153,072,240.73	186,008,283.34
210201	Тэтгэврийн даатгал	104,433,039.39	127,033,521.03
210202	Тэтгэмжийн даатгал	12,242,480.08	14,912,259.21
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,019,719.81	7,483,547.29
210204	Ажилгүйдлийн даатгал	6,049,803.78	7,340,011.77
210205	Эрүүл мэндийн даатгал	24,327,197.67	29,238,944.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	336,482,691.49	475,549,103.25
210301	Гэрэл, цахилгаан	24,749,091.49	28,453,103.25
210302	Түлш, халаалт	307,557,600.00	429,000,000.00
210303	Цэвэр, бохир ус	4,176,000.00	18,096,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	43,746,891.34	244,000.00
210401	Бичиг хэрэг	14,599,010.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	29,147,881.34	244,000.00
2105	Нормативт зардал	36,030,070.80	44,913,508.00
210502	Хоол, хүнс	36,030,070.80	44,913,508.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,165,330.35	25,877,047.15
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,928,000.00	2,843,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,237,330.35	23,033,247.15
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	239,841,546.43	313,047,583.02
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,633,700.00	42,757,601.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	80,000.00	10,521,770.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	220,127,846.43	259,768,212.02
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	49,266,161.51	77,384,698.75
2132	Бусад урсгал шилжүүлэг	49,169,973.00	66,573,802.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	49,169,973.00	66,573,802.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	96,188.51	10,810,896.75

213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	99,188.51	10,810,896.75
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	116,390,092.42	(252,553,173.41)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	156,434,982.00	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	156,434,982.00	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(156,434,982.00)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(40,044,889.58)	(252,553,173.41)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,022,837,848.00	2,234,458,034.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,212,348.00	19,977,534.00
120	Нийтлэг татварын бус орлого	10,212,348.00	19,977,534.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10,212,348.00	19,977,534.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,928,000.00	2,811,400.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,284,348.00	17,166,134.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,012,625,500.00	2,214,480,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,671,046,700.00	1,723,120,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,671,046,700.00	1,723,120,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	341,578,800.00	491,360,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	341,578,800.00	491,360,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,896,794,322.41	2,373,322,854.69
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,896,794,322.41	2,373,322,854.69
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,850,448,614.90	2,296,366,497.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,224,161,797.53	1,481,016,322.20
210101	Үндсэн цалин	783,332,353.29	912,482,252.85
210102	Нэмэгдэл	393,067,285.67	478,169,902.35
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	49,591,664.00
210104	Урамшуулал	47,762,158.57	40,772,503.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	153,135,870.73	186,008,283.34
210201	Тэтгэврийн даатгал	104,433,039.39	127,033,521.03
210202	Тэтгэмжийн даатгал	12,242,480.08	14,912,259.21
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,019,719.81	7,483,547.29
210204	Ажилгүйдлийн даатгал	6,049,803.78	7,340,011.77
210205	Эрүүл мэндийн даатгал	24,390,827.67	29,238,944.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	336,482,691.49	475,549,103.25
210301	Гэрэл, цахилгаан	24,749,091.49	28,453,103.25
210302	Түлш, халаалт	307,557,600.00	429,000,000.00
210303	Цэвэр, бохир ус	4,176,000.00	18,096,000.00
2105	Нормативт зардал	37,778,299.80	45,341,850.00
210502	Хоол, хүнс	37,778,299.80	45,341,850.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,999,920.00	5,000,000.00
210604	Урсгал засвар	4,999,920.00	5,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,165,330.35	25,877,047.15
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,928,000.00	2,843,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,237,330.35	23,033,247.15
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	82,724,705.00	77,573,892.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	70,110,935.00	68,734,592.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,613,770.00	8,839,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	46,345,707.51	76,956,356.75

2132	Бусад урсгал шилжүүлэг	46,249,519.00	66,145,460.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	46,249,519.00	66,145,460.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	96,188.51	10,810,896.75
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	96,188.51	10,810,896.75
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	126,043,525.59	(138,864,820.69)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	126,043,525.59	(138,864,820.69)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	112,758,177.89	238,801,703.48
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	238,801,703.48	99,936,882.79

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	521,977,813.50	1,426,196,332.51	6,442,943,869.51	8,391,118,015.52
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	521,977,813.50	1,426,196,332.51	6,442,943,869.51	8,391,118,015.52
Тайлант үеийн үр дүн	-	-	(40,044,889.58)	(40,044,889.58)
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	521,977,813.50	1,426,196,332.51	6,402,898,979.93	8,351,073,125.94
2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	521,977,813.50	1,426,196,332.51	6,402,898,979.93	8,351,073,125.94
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	521,977,813.50	1,426,196,332.51	6,402,898,979.93	8,351,073,125.94
Тайлант үеийн үр дүн	-	-	(252,553,173.41)	(252,553,173.41)
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	521,977,813.50	1,426,196,332.51	6,150,345,806.52	8,098,519,952.53

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
11000	Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл	238,801,703.48	99,936,882.79	138,864,820.69
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,996,390,300.00	1,881,952,854.69	114,437,445.31
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,996,390,300.00	1,881,962,854.69	114,427,445.31
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,921,896,400.00	1,815,817,394.69	106,079,005.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,556,674,700.00	1,481,016,322.20	75,658,377.80
210101	Үндсэн цалин	975,075,100.00	912,482,252.85	62,592,847.15
210102	Нэмэгдэл	566,988,600.00	478,169,902.35	88,818,697.65
		-	49,591,664.00	(49,591,664.00)
210104	Урамшуулал	14,611,000.00	40,772,503.00	(26,161,503.00)
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	194,669,900.00	186,008,283.34	8,661,616.66
210201	Тэтгэврийн даатгал	132,375,500.00	127,033,521.03	5,341,978.97
210202	Тэтгэмжийн даатгал	15,573,500.00	14,912,259.21	661,240.79
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,786,800.00	7,483,547.29	303,252.71
210204	Ажилгүйдлийн даатгал	7,786,800.00	7,340,011.77	446,788.23

Дорнод аймгийн Халхгол сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210205	Эрүүл мэндийн даатгал	31,147,300.00	29,238,944.04	1,908,355.96
2105	Нормативд зардал	58,411,200.00	45,341,850.00	13,069,350.00
210502	Хоол хүнс	58,411,200.00	45,341,850.00	13,069,350.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,741,100.00	25,877,047.15	4,864,052.85
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,303,200.00	2,843,800.00	2,459,400.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээ	25,437,900.00	23,033,247.15	2,404,652.85
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	81,399,500.00	77,573,892.00	3,825,608.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	72,542,200.00	68,734,592.00	3,807,608.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,857,300.00	8,839,300.00	18,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	74,493,900.00	66,145,460.00	8,348,440.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	74,493,900.00	66,145,460.00	8,348,440.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	74,493,900.00	66,145,460.00	8,348,440.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	-	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,996,390,300.00	1,881,952,854.69	-
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,747,539,400.00	1,723,120,500.00	-
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,747,539,400.00	1,723,120,500.00	-
	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	248,850,900.00	158,832,354.69	90,018,545.31
	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,303,200.00	2,811,400.00	2,491,800.00
	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,790,600.00	17,166,134.00	3,624,466.00
	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	222,757,100.00	138,854,820.69	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	238,801,703.48	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	99,936,882.79	-

2.6 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	491,360,000.00	491,360,000.00	-
21	УРСГАЛ ЗАРДАЛ	491,360,000.00	491,360,000.00	-
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	491,360,000.00	480,549,103.25	10,810,896.75
2103	БАЙР АШИГЛАЛТАЙ ХОЛБООТОЙ ТОГТМОЛ ЗАРДАЛ	486,360,000.00	475,549,103.25	10,810,896.75
210301	Гэрэл, цахилгаан	39,264,000.00	28,453,103.25	10,810,896.75
21302	Түлш халаалт	429,000,000.00	429,000,000.00	-
21303	Цэвэр, бохир ус	18,096,000.00	18,096,000.00	-

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,000,000.00	5,000,000.00	-
210604	Урсгал засвар	5,000,000.00	5,000,000.00	-
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	491,360,000.00	491,360,000.00	-
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг		10,810,896.75	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	-	-
131103	ЗГНХ, ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	-	-

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2,210.5 мянган төгрөгийн зөрчил¹ илэрсэнд 1 албан шаардлага, өмнөх оны алдаа зөрчлийг давтан гаргасан зөрчилд хариуцлага тооцох 1 албан шаардлага хүргүүлж байна.

3.1 Албан шаардлага

- Худалдан авалтын тендерийн техникийн тодорхойлолтод тусгасан барааны нэр төрлөөс өөр нэр төрлийн 2,210.5 мянган төгрөгийн бүтээгдэхүүнийг тайлант хугацаанд гүйцэтгэлээр худалдан авсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, 16 дугаар зүйлийн 16.5.1-д Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах, 16.5.2-т Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.3-т “Бараа, ажил, үйлчилгээ хамтран худалдан авах төсвийн шууд захирагч тус тусын худалдан авах бараа, ажил, үйлчилгээний хувьд гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавина” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.
- Өмнөх оны аудитаар худалдан авах ажиллагаатай холбоотой алдаа зөрчлийг давтан гаргасан тул албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэв.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчил.								
Худалдан авалтын тендерийн техникийн тодорхойлолтод тусгасан барааны нэр төрлөөс өөр нэр төрлийн бүтээгдэхүүнийг тайлант хугацаанд гүйцэтгэлээр худалдан авсан	1	2,210.5			1	2,210.5		

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Дорнод аймгийн Халхгол сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Өмнөх оны аудитаар худалдан авах ажиллагаатай холбоотой албан шаардлага хүргүүлж байсан алдаа зөрчлийг давтан гаргасан	1	-					1	-
Нийт дүн	2	2,210.5			1	2,210.5	1	-